



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 1/45

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 16 зүйлийн 16.2, 16.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 28.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Дэлгэрхаан суманд үйл ажиллагаа эрхлэх "Хүннү хөдөө арал" рашаан сувилалд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай шинээр олгосугай.

Хоёр. Дээрх рашаан сувилалын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаад/-д даалгасугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 384